

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
ЕСДҮГЭЭР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2020.09.01-2020.09.30/

2020 оны 09 дүгээр сарын 30

Даланзадгад хот

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Виз, зөвшөөрлийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд “Монгол Улсын Виз олгох журам”-ын 6.2-т заасны дагуу ачаа тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Божманайзууд” ХХК-ийн БНХАУ-ын 2 иргэн, “Тавантолгой транс” ХХК –ийн 40 иргэн нийт БНХАУ-ын 42 иргэний визийн сунгалтын материалыг бүрдүүлэн төв газарт хүргүүлж, холбогдох дансанд тэмдэгтийн хураамжийн 2,343,600 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар: Тайлант хугацаанд БНХАУ-ын 25 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч төвд хүргүүлсэн.

Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

Байгууллагын даргын 2020 оны 01, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг долоо хоногийн даваа гариг бүр холбогдох нэгжид хүргүүлэн ажиллаж байна.

Албан хаагчдыг ая тухтай ажиллаж амьдрах нөхцөлөөр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хилээр орж гарах тэнхимийн тусламжаар тус газарт баригдах албаны байр, орон сууцны цогцолбор барилгын ажил 08 дугаар сарын 14-ний өдрөөс эхэлж, гүйцэтгэгчээр “Преспектив актив констракшн” ХХК ажиллаж байгаа билээ. Бүсийн газраас барилгын ажилд хяналт тавьж, хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар барилгын карказ цутгалтын ажил үргэлжлэн хийгдэж байна.

Бүсийн газар нь НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт байрлах Шивээхүрэн авто замын боомтод ажиллаж буй хил хяналтын байгууллагын албан хаагчдад энэ оны 09 дүгээр сарын 08-09-ний өдрүүдэд “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, хамгаалах, хохирогчид туслалцаа үзүүлэх” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтад бүсийн газрын 5 албан хаагч, Хилийн 0166 дугаар ангийн 17, Өмнөговь аймгийн Шивээхүрэн дэх Гаалийн газрын 7, Өмнөговь аймаг дахь Мэргэжлийн хяналтын газрын 6, нийт 35 албан хаагч хамрагдсан болно.

Албан хаагчдаас ажлын байрны зураг авалттай холбоотой дэлгэрэнгүй судалгааг авч, нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн.

1.1.Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/-1
- Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо-1
- Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
- Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-1/
- Төв газарт явуулсан бичиг /илтгэх хуудас-9/
- Явуулсан бичиг /албан тоот-8/
- Бусад байгууллагаас ирсэн бичиг- 3
- Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-0

1.2.Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр:

Энэ оны 09 дүгээр сард 360,990,700 төгрөгийн санхүүжилт авч нийт 21 албан хаагчийн цалинд 206,660,885 төгрөгийг олгож, нийгмийн даатгалын шимтгэлд 26,306,902 төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 15,214,748 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 21,097,869 төгрөгийн гүйлгээг Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан хийж ажилласан байна.

Тус газрын 2020 оны 08 дугаар сарын шилэн дансны мэдээллийг цахим сайтад байршуулж тоон мэдээг хуульд заасан хугацаанд холбогдох нэгжид хүргүүлж ажилласан.

1.3.Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд албан хаагчдаас сүлжээ тасалдсан, компьютерийн хэвийн бус ажиллагаатай холбоотой нийт 4 дуудлага ирүүлснийг тухай бүр засч сайжруулан ажилласан.

Хоёр. Бусад

2.1 Шинэ коронавирусын /ковид-19/ дэгдэлттэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Өмнөговь аймгийн онцгой комисс болон байгууллагын даргын гаргасан шийдвэрүүдийг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Тухайлбал, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор гар ариутгах бодисоор ханган, албаны өрөөнүүдийн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтлийг сайжруулан ажиллаж байна.

Мөн байгууллагын даргын гаргасан албан даалгаврын биелэлт, уг вирусээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.